

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 21 2023 оны 9-р сар

САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ЁСЛОЛ

Салхитын уурхайн Хаалтын менежментийн төлөвлөгөөний жишиг төслийг хүлээлгэн өгөх ёслол энэ оны 7-р сарын 2, 3-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Канад улсын Элчин сайдын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Дундговь аймаг, Гурвансайхан сумын нутгийн захиргааны байгууллагын төлөөллүүд, Уул уурхайн компаниуд, сургалтын байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн нийт 70 оролцогч оролцлоо.

Чуулганы гол зорилго нь жишиг төслийн хүрээнд боловсруулсан Салхитын уурхайн Хаалтын менежментийн төлөвлөгөөг MERIT төслөөс Эрдэнэс Силвер Ресурс (ЭСР) ХХК-д албан ёсоор шилжүүлж, цаашид төлөвлөгөөг шинэчлэх, хэрэгжүүлэх, батлуулах зэрэг ажлууд нь тус компанийн хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлага болохыг мэдэгдэв. Түүнчлэн уурхайн хаалтын төлөвлөлтийг уул уурхайн салбарт үр дүнтэй хэрэгжүүлэх туршлага, стратеги бүхий зөвлөмжүүдийг төрийн албан хаагчид болон салбарын оролцогч талуудад танилцуулж, санал нэгдэв.



Зураг 1: MERIT төсөл нь Салхитын уурхайн хаалтын менежментийн жишиг төлөвлөгөөг УУХҮЯ, БОАЖЯ, Эрдэнэс Силвер Ресурс ХХК-д хүлээлгэн өгөх дөрвөн талт Санамж бичигт гарын үсэг зурлаа.

ПАНАЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Зураг 2: Салхитын уурхайн ХМТ боловсруулах жишиг төслийн хэрэгжилтийн үр дүн - Панел хэлэлцүүлэг

Тус чуулганы үеэр ХМТ-ний жишиг төслийн явцад олж авсан сургамж, үр дүн болоод цаашид хаалтын төлөвлөлтийг урт хугацаанд хэрхэн тогтвортой хэрэгжүүлж, төлөвшүүлэх талаарх салбарын бодлого зэрэг үндсэн хоёр сэдвийн хүрээнд панел хэлэлцүүлэг өрнүүлэв. Хэлэлцүүлгийн үеэр нөлөөллийн бүс буюу Дундговь аймгийн Гурвансайхан сум болон Чулуут багийн иргэдийн төлөөллүүд уурхайн хаалтын болон хаалтын дараах үеийн нийгэм, эдийн засгийн шилжилттэй холбоотой өөрсдийн санал болоод санаа зовниж буй асуудлуудаа илэрхийлж байв.

Хэлэлцүүлгийн үеэр Эрдэнэс Монгол ХХК-ний Гүйцэтгэх захирал С.Наранцогт Салхитын ХМТ-г хэрэгжүүлэхэд бүрэн дэмжихээ илэрхийлээд, цаашид Эрдэнэс Монгол ХХК-ийн харьяа уул уурхайн компаниудад уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд онцгой анхаарч ажиллахаа илэрхийлэв. УУХҮЯ-ны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр тус жишиг төсөл нь оролцогч талуудыг өргөн хүрээнд хамруулж, уурхайн хаалтын төлөвлөлтийн ач холбогдлын талаарх талуудын ойлголтыг маш сайн бэхжүүлж чадсаныг онцлов. ЭСР ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Баярмөнх нь Монгол улсад жишиг байдлаар хэрэгжиж, боловсруулсан төслийг компанийн хувьд өндөр хариуцлагатайгаар хэрэгжүүлэхээ мэдэгдэв. Мөн төсөл хэрэгжиж эхэлснээс хойш бусад хувийн уул уурхайн компаниудын Салхитын уурхайн ХМТ-ийн төлөвлөлтийн туршлагаас суралцах хүсэл эрмэлзэл нэмэгдэж байгааг онцоллоо.

УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРТ НЭВТРҮҮЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Жишиг төслийн хүрээнд MERIT төслөөс “Уурхайн хаалтын төлөвлөлтийг Монгол улсад хэрэгжүүлэх зөвлөмж” бүхий тайланг боловсруулж, 2023 оны 7-р сард холбогдох төрийн байгууллагын төлөөллүүд болон бусад оролцогч талуудад танилцуулсан билээ. Уг тайланд Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд, уул уурхайн компаниуд, иргэд, сургалтын байгууллагууд, үндэсний зөвлөх компаниуд зэрэг нийт таван шатны оролцогч талуудад зориулсан зөвлөмжийг багтаасан. Учир нь эдгээр оролцогч талууд нь Монгол улсын уул уурхайн салбарт Уурхайн хаалтын төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэх юм.



Зураг 3: Ёслолын ажиллагааны үеэр Салхитын уурхайн ХМТ-ний жишиг төслийн ахлах зөвлөх СиПиПи Энвйронментал корпорацийн ерөнхийлөгч Майк Посенте нь Уурхайн хаалтын төлөвлөлтийг Монгол улсын Уул уурхайн салбарт хэрэгжүүлэх талаарх зөвлөмжийг танилцуулж байна.


Төрийн захиргааны төв байгууллагуудын үүрэг, оролцоо

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) уурхайн хаалтыг үндэсний хэмжээнд хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, зөвлөмжийн хэрэгжилтийн явцыг хянах үүрэгтэй (1 зөвлөмж).
- БОАЖЯ нь хуулийн хэрэгжилтийг хангуулах бодлого, дүрэм журмыг боловсруулж, уурхайн хаалтын үйл ажиллагаанд шаардагдах стандарт шаардлагыг тодорхой болгох, уул уурхайн салбарт тус бодлогыг тэгш, тэнцвэртэй байдлаар мөрдүүлж ажиллах. (1 зөвлөмж).
- УУХҮЯ, БОАЖЯ нь үр дүнд суурилсан хаалтын төлөвлөлтийг дэмжих, чиглүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартуудыг шинэчлэхэд хамтран ажиллах. (1 зөвлөмж)
- Аймаг, сумын ЗДТГ, өөрөө удирдах ёсны байгууллагууд уурхайн хаалтын талаар уул уурхайн компаниудтай харилцан ойлголцож, хамтран ажиллахын тулд орон нутгийн оролцогч талуудын чадавхийг үнэлж, төсөл хэрэгжүүлэгч компанийн орон нутгийг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөөндөө шаардлагатай арга хэмжээг тусгаж ажиллах талаар хэлэлцээр хийх. (1 зөвлөмж)
- Холбогдох яам, агентлаг, Уул уурхайн компаниуд, Үндэсний зөвлөх компаниуд ажилчид, албан хаагчдынхаа ур чадварыг тогтмол үнэлж, уурхайн хаалтын үндсэн асуудлууд, технологи, шилдэг туршлагын талаарх мэдлэг чадвар, ойлголтыг тодорхойлж, нэмэлт сургалт явуулах.
- Монгол улсын уул уурхай, олборлох салбарын хүний нөөцийг бэлтгэдэг дотоодын их дээд сургууль, коллежууд нь одоо ажиллаж буй салбарын хүний нөөцийн уурхайн хаалтыг төлөвлөх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор богино хугацааны сургалтын хөтөлбөрийг боловсруулах. Сургалтын байгууллагууд нь уурхайн ХМТ-ний үйл явц, олон улсын сайн туршлагын талаарх мэдлэг чадварыг олгох сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, сайжруулах хэрэгтэй. Эдгээр хөтөлбөр нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц байх. (2 зөвлөмж)
- Уул уурхайн компаниуд нь уурхайн хаалтын төлөвлөлтөд нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлж, жендэрийн эрх тэгш байдлыг харгалзахын зэрэгцээ иргэдийн сургалт, хэлэлцүүлгээр дамжуулж тэдний чадавхыг нэмэгдүүлэх (2 зөвлөмж)
- УУХҮЯ нь уурхайн хаалтын төлөвлөлтийн талаарх орон нутгийн оролцогч талуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд "Уурхайн амьдралын мөчлөг" сургалтын хөтөлбөрийг уурхайн нөлөөлд өртсөн иргэдэд хүргэхэд анхаарах (1 зөвлөмж)
- Уул уурхайн компаниуд нь хаалтын төлөвлөгөөг хийхэд оролцох орон нутгийн байгууллагууд, иргэдэд уурхайн талбайг харуулах, уурхайн нөхцөл байдлыг бодитоор танилцуулах арга хэмжээг аль болох төлөвлөлтийн эрт үед зохион байгуулж, тэдний саналыг авах (1 зөвлөмж)

Нөөц

- Уул уурхайн компаниуд нь мэргэжлийн холбоодоор дамжуулан уурхайн хаалтын арга ажиллагаан дахь дутагдалтай талуудыг тодорхойлж, Монголын уул уурхайн салбарт хэрэглэгдэх үр дүнтэй удирдамж, гарын авлага бүхий баримт бичгийг боловсруулахад оролцогч талуудтай хамтран ажиллах (1 зөвлөмж)
- Уул уурхайн компаниуд нь холбоод байгуулж салбартаа хаалтын менежментийг хэрэгжүүлэхэд тулгардаг судалгаа шинжилгээ, технологитой холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд хамтран ажиллах нь зүйтэй (1 зөвлөмж)
- УУХҮЯ нь Монгол Улсын Засгийн Газрыг төлөөлөн "Уул уурхай, металлын олон улсын зөвлөл" (ICMM)-өөс эрхлэн гаргадаг "Уурхайн хаалтын нэгдсэн удирдамж, сайн туршлага" гарын авлагыг цаашид хаалтын төлөвлөлтийн лавлах эх сурвалж болгон ашиглах зорилгоор монгол хэл рүү орчуулах албан ёсны эрхийг авах (1 зөвлөмж)
- Уул уурхайн компаниуд хаалтын төлөвлөлтийн хэрэгцээгээ үнэлж, тухайн уурхайн хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран ХМТ хэрэгжүүлэх стратеги болон төсөв санхүүжилтээ гаргах ёстой (1 зөвлөмж)
- Уурхайн ХМТ боловсруулахад оролцох зөвлөх компаниуд GIS программыг худалдан авч ашиглах, ХМТ-д шаардлагатай газарзүйн мэдээллийн системийн зураглал боловсруулах, өндөр чанартай үйлчилгээ, орон зайн өгөгдлийн дүн шинжилгээ хийх чадавхийг нэмэгдүүлэх шаардлагатай (1 зөвлөмж)

Уурхайн хаалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх албан ёсны хугацаа хараахан батлагдаагүй ч, бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах бодит хугацаа нь 8 жил болохыг зөвлөж байна. Доорх зурагт оролцогч талуудын бүлэг тус бүрээр хэрэгжүүлэх зөвлөмжийн тоо болон цагалбарыг харуулж байна.



Уул уурхайн салбарын хэмжээнд хаалтын цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь жижиг, дунд уурхайнуудын хувьд харьцангуй шинэ туршлага юм. Монгол Улсад уурхайн хаалтын менежментийг хэрэгжүүлэх одоогийн чадавх сул байна. Харин бодлого, стандартыг боловсронгуй болгох, хаалтыг төлөвлөж ажиллах мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, удирдамж, гарын авлага бүхий баримт бичиг боловсруулах, уул уурхайн салбарын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх зэрэг нөөц боломжууд байна гэж дүгнэв. Уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө (ХМТ)-г амжилттай хэрэгжүүлснээр олон улсын түвшинд хариуцлагатай уул уурхай, олборлох салбар дахь Монгол Улсын нэр хүнд өсөх боломжтой юм.

ХОЛБОО БАРИХ

Бид та бүхэнд Салхитын уурхайн хаалтын мэдээ мэдээллийг аль болох сонирхолтой байдлаар хүргэхийг зорьдог билээ. Төслийн оролцогч талуудын санал, сэтгэгдлийг сонсож, бэлтгэж буй мэдээ мэдээллийг уншигчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх нь чухал юм. Тиймээс та бүхэн төслийн сар тутмын мэдээтэй холбоотой санал сэтгэгдлээ бидэнтэй хуваалцана уу.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн захирал
Р.Алтангэрэлтэй имэйл хаягаар холбогдоно уу.
r.altangerel@merit.mn